

Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орлоо.

2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хурал Нийгмийн Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг (цаашид “Нэмэлт өөрчлөлт гэх”) баталсан бөгөөд тус хууль нь 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

Холбогдох хаяг:

Майкл Ахэрн

Партнер, Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
michael.ahern@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Гүйцэтгэх захирал, Татвар, Хуулийн
зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Марина Тарнавская

Ахлах Менежер
tarnavska.maryna@pwc.com

ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068
www.pwc.com/mn

1994 оны 6 дугаар сарын 9-ны өдрийн Нийгмийн Даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 2017 оноос эхлэн 2021 он хүртэл 7%-иас 9.5% болтол үе шаттайгаар нэмэгдүүлэхээр байсан. Улмаар даатгалын төрлүүдээс хамгийн өндөр хувь хэмжээтэй болох тэтгэврийн даатгалын шимтгэлийн нөлөөллөөр 2021 оны 1-р сарын 1-нээс нийгмийн даатгалын шимтгэлийн нийт хувь хэмжээ ажил олгогчийн хувьд 13.5% -15.5%, ажилтны хувьд 12.5% болохоор байсан.

Гэвч коронавируст халдварын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан 2020 оны 4 дүгээр сарын 9-ны өдөр баталж, 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсөн “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль”-иар зөвхөн Монгол Улсын иргэдэд хамаарах хөнгөлөлтийг эдлүүлсэн. Үүний дагуу 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хуульд заасан төлбөл зохих хэвийн хувь хэмжээгээр бус хөнгөлөлттэй хувь хэмжээгээр нийгмийн даатгалын шимтгэл мөрдөгдсөн бол 2021 оны 7 дугаар сарын 1-ээс эхлэн хуульд заасан хэвийн хувь хэмжээ мөрдөгдөхөөр байсан.

Гэсэн хэдий ч, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр тэтгэврийн даатгалын шимтгэлийн 9.5 хувийг 8.5 хувь болж буурч байна.

Нийгмийн даатгалын төрөл	Хуульд заасан хувь хэмжээ		(КОВИД-ын үеийн хөнгөлөлттэй хувь хэмжээ)		Нэмэлт Өөрчлөлтөөр шинэчлэгдсэн Хувь хэмжээ	
	2021.01.1-2021.07.01		2021.01.1-2021.07.01		2021.07.01-с эхлэн	
	Ажил олгогч	Ажилтан	Ажил олгогч	Ажилтан	Ажил олгогч	Ажилтан
Тэтгэвэр	9.50%	9.50%	8.50%	8.50%	8.50%	8.50%
Тэтгэмж	1.00%	0.80%	0.00%	0.00%	1.00%	0.80%
Эрүүл мэнд	2.00%	2.00%	2.00%	2.00%	2.00%	2.00%
Ажилгүйдэл	0.20%	0.20%	0.00%	0.00%	0.20%	0.20%
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс хамаарах өвчин*	0.80%-2.80%	0.00%	0.00%	0.00%	0.80%-2.80%	0.00%
Нийт	13.50%-15.5%	12.50%	10.50%	10.50%	12.50%-14.5%	11.50%

*Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагаас хамаарч 0.8%-2.8%. хүртэл хувиар ялгавартай тогтоодог.

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах линкнээс авна уу.

<https://www.legalinfo.mn/additional/details/3991?lawid=390>

Энэхүү мэдээлэлтэй холбоотой нэмж тодруулах зүйл байвал бидэнтэй холбогдоно уу.



Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.